



Миний шинэ бэлтгэл сургууль



1968 оны Зохиогчийн Эрхийн тухай Хууль (Copyright Act 1968 (Cth)) or licensed under болон [Getty Images Content License Agreement](#) ээр баталгаажигдсан iStock лицензийн дор энэхүү баримтанд орсон бүх дүрсэлбэр нь NSW мужийн Боловсролын Яамны өмч болно.

Энэ бол миний шинэ сургуулийн хаалга.



Надад нуруундаа үүрээд явдаг бэлтгэл ангийн хичээлийн цүнх байдаг. Би сургуульдаа ирээд цүнхээ тусгай зориулсан байранд тавьдаг.



Би бэлтгэл ангидаа ирэхдээ савласан өдрийн хоол болон савтай ус авчирдаг. Ам цангахаараа усаа уудаг.



Сургууль дээр өмсөх малгай надад байдаг. Би малгайгаа гадаа тоглохдоо нарнаас хамгаалахын тулд өмсдөг.



Сургууль дээр байхад том хүмүүс надад анхаарал халамж тавьдаг бөгөөд бас надад сурахад минь тусладаг. Гунигтай болохоороо би тэдэнд үүнийгээ хэлдэг ба тэд намайг тайтгарахад минь тусладаг. Бие биендээ сайхан хандаж бай гэж хүүхэд бүрт томчуул хэлдэг юм.



Надад сургууль дээрээ хамт тоглох хуучин найзууд маань байдаг бөгөөд шинэ найзуудтайгаа ч гэсэн би тоглодог. Гэхдээ зарим өдөр би ганцаараа тогломоор ч санагддаг.



Сургууль дээр тоглох зөндөө олон янзын зүйлс бий.
Ямар тоглоомоор тогломоор байгаагаа би өдөр бүр өөрөө
сонгодог. Хөгжилтэй байж шинэ зүйл сурах нь надад
таалагддаг.



Анги дотор тоглож байхдаа би цаасаар, цаасан саваар юм хийх дуртай. Би уйтгар гунигтай байвал гэртээ хийдэг шигээ блок өрж тоглох дуртэй.



Гадаа тоглохдоо гүйж харайх, мөн аливаа зүйлс рүү авиран гарах дуртай. Мөн би элсэн дээр тоглох дуртай.



Тоглоомын цаг дуусахаар тоглоомнуудаа буцаан байранд нь тавихад нь би тусладаг. Сургуулиа цэгцтэй сайхан байлгаж санаа тавих нь сайн зүйл юм.



Заримдаа томчуул болон хүүхдүүд хамтдаа шинэ зүйл суран дуу дуулцгаадаг. Бас миний гэртээ хийдэгтэй ижилхэн томчуултай хамтдаа үлгэр ярих нь гоё байдаг.



Миний хамраас нуж гоожоод байвал би салфетка хэрэглэн нусаа нийгээд хэрэглэсэн салфеткаа хогийн саванд хийж гараа угаана гэдгээ мэддэг.



Манай сургууль том ариун цэврийн өрөөтэй. Бие засах бол би ариун цэврийн өрөөнд ордог. Дууссаны дараа би усаа татаж гараа угаадаг.



Би гараа савантай усаар угааж дараа нь гараа хатаадаг. Гараа угаах ёстой гэдгээ би үргэлж санадаг, тэгэхдээ би мундаг шүү. Би гараа угааж байвал бүх муу бактерийг арилган тэгснээрээ би эрүүл байх болно.



Би өдрийн хоолоо бусад хүүхдүүдтэй хамт иддэг. Хэрэв би хоолоо уутнаасаа гаргаж чадахгүй байвал томчуудыг туслахыг хүсдэг. Хүч чадалтай эрүүл болохын тулд би үргэлж эрүүл хоол хүнс иддэг. Хэрвээ би хоолоо идэж дуусгаж чадахгүй бол үлдсэн хоолоо саванд нь хийгээд гэр рүүгээ авч явдаг.



Өдрийн хоолоо идсэний дараа чимээгүй цаг эхэлдэг. Бүх хүүхдүүд ном үзэх, таавар таах, зураг зурах гэх мэтээр чимээгүй орчинд байдаг. Хэрэв би ядарсан бол хэвтэж амардаг.



Гэртээ харих цаг дөхөхөөр би цүнхэндээ өөрийнхөө юмаа хийж үүрээд явахад бэлэн болдог.



Сургуулийн өдөр дуусахаар бүх хүүхдүүдийг том хүмүүс ирж авч явдаг.



Би явахдаа томчуул, хүүхдүүдэд баяртай гэж хэлэн инээмсэглэдэг. Би “Хамт тоглосонд баярлалаа, дараа уулзъя” гэж хэлдэг. Бүх хүүхдүүд явж дуусахаар бэлтгэл сургууль маань хаадаг.

